

Дүгнэлт, цаашид
авах арга хэмжээний
талаарх зөвлөмж

Д.Баярхүү
Орос ШХАБ-д

Д.Уламбаяр
Олон туйлт дэлхийн шинэ
дэг тогтолцоо төлөвших
үйл явц ба монгол улс

Т.Заяа
Өөртөө засан
тогтнох эрх үү,
сепаратизм уу?

БОДЛОГЫН МЭДЭЭ

POLICY NEWS

AD CURRAM ET COMMUNICO!

2018.05 №8



Бодлогын судалгааны төв
Монгол Улсын Их Сургууль
Олон Улсын Харилцаа,
Нийтийн Удирдлагын Сургууль

РЕДАКЦИЙН ЗУРВАС

01 Халуун сэдэв

БСТ-ИЙН ТӨСЛИЙН СУДАЛГАА

02 Дүгнэлт, цаашид авах арга хэмжээний талаарх зөвлөмж

ХӨРШ ОРНУУД

05 Орос ШХАБ-д

06 “Нэг бүс, нэг зам”-ын бэлчирт

ОЛОН УЛСАД

08 Олон туйлт дэлхийн шинэ дэг тогтолцоо төлөвших үйл явц ба Монгол улс

ОНЦЛОХ СЭДЭВ


11 Өөртөө засан тогтнох эрх үү, сепаратизм уу?

Дугаарыг эрхлэн бэлтгэсэн:

Х.Бэхбат

Эх бэлтгэгч:
Хэвлэсэн газар:

Х.Балдандорж
“Удам Соёл” ХХК



Халуун сэдэв

Цаг агаар хэмжигчийн зүү зуны аагим халуун +30 хэм заах гэж тэмүүлэх явдал тавдугаар сард ховор тохиолддог шиг санагдна. Үүнтэй давхцан гадаад бодлогын нэгэн сэдэв халуурсан нь яриангүй **ШХАБ** мөн. Энэ байгууллагад жинхлэх, эс жинхлэх асуудлаар дээр, дооргүй, бас чиг шаггүй эрс тэс марган мэтгэлцэхийг харахуйд инээд ч хүрмээр, эмгэнэл ч илэрхийлмээр ажгуу.

Инээх аядахын учир нь эдүгээг хүртэл ямар бодлого, ямар зорилго, зарчмаар явуулж ирснээ тун ч амархан умартах эрсдэлд орших бус уу. Эмгэнэхийн учир нь ч мөн адилхаан.

Харин та бид өөрийн болоод бусдын бодлогын наад, цаадыг бүрэн төнхөхгүй, цаг зуурын давалгаанд юутай амархан өртөж болохоо дахин нэг ухаарах цаг ирэв бололтой...

Х.Бэхбат

* * *

All of us are neck deep in politics everyday of our lives. Every organization on earth that involves human beings has its politics. Politics does not have to be a bad thing. Actually politics can be a good thing when we bring people to the table to sit down, work together, compromise and get things done for the common good.

BILL GINDLESPERGER

If a political party does not have its foundation in the determination to advance a cause that is right and that is moral, then it is not a political party; it is merely a conspiracy to seize power.

DWIGHT D. EISENHOWER

I used to say that politics was the second-oldest profession. I have come to know that it bears a gross similarity to the first.

RONALD REAGAN

“Шанхайн хамтын ажиллагааны байгууллага /ШХАБ/ дахь Монгол Улсын цаашдын оролцоо” сэдвээр БСТ-өөс захиалан гүйцэтгүүлсэн судалгааны талаар өмнөх дугааруудад мэдээлсэн. Уг судалгааны ажлын дүнг товхимол хэлбэрээр хэвлэж холбогдох газруудад хүргэсэн билээ. Энэ удаа уг судалгааны ажлын дүгнэлт, зөвлөмжийг илүү өргөн олонд танилцуулах зорилгоор нийтэлж байна.

Х.Бэхбат

ДҮГНЭЛТ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ ЗӨВЛӨМЖ

ШХАБ нь байгуулагдсанаасаа хойшхи хугацаанд тодорхой амжилтад хүрч, зорилго, хэтийн төлвөө тодорхойлж, хамтын ажиллагааны механизм, санхүү, эрх зүйн үндсийг бүрдүүлэн харьцангуй тогтворжиж, бүс нутгийн нөлөө бүхий байгууллага болох төлөвтэй байна. Ажиглагч, яриа хэлцээний түнш орнууд нэмэгдэж нийт оролцогч орны тоо 18-д хүрлээ. Тус байгууллагад Энэтхэг, Пакистан улсыг гишүүнээр элсүүлснээр байгууллагын хамрах хүрээ, нөлөө өсөхөөс гадна байгууллагын шинж төрх, чиглэлд цаашдын өөрчлөлт орох магадлал байна.

Нөгөөтэйгүүр, ШХАБ бүрэн институтчилэгдэж чадаагүй, хамтарсан төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх санхүүгийн нэгдсэн сан хөмрөг байхгүй байгаа, зарим гол гишүүн орнуудын үндэсний эрх ашгийн зөрчил ялгаа нь бүс нутгийн хамтын ажиллагааг илүү өндөр түвшинд хүргэж чадахгүй байгаагийн гол шалтгаан болж байна. Хэдийгээр эдийн засгийн хамтын ажиллагааны асуудалд эдүгээ түлхүү анхаарах болсон ч улс төр, аюулгүй байдал, чухамдаа глобал геополитикийн ашиг сонирхлын зөрчил тэмцлийн үр дүн хэвээр байна.

Манай улсын хувьд ШХАБ-ын гишүүнчлэлийн шалгуурыг хангаж буй, мөн гишүүн орнуудын

дэмжлэгийг авах боломж бий. Хоёр хөрш орны зүгээс ч манай улсыг гишүүнээр элсэхийг ятгах явдал бий. Гишүүн болохоос хэт цааргалвал хоёр хөрш оронтой харилцах харилцаанд сөрөг нөлөө үзүүлэх, бүс нутгийн эдийн засгийн интеграциас хоцорч, анхаарлын гадуур үлдэх эрсдэл бий.

Тус байгууллагын анхны ажиглагч болох манай улс ийм статустай болоод 13 жил болж буй, манайхаас хойно ажиглагч болсон Энэтхэг, Пакистан жинхэнэ гишүүн болоод байгаатай холбоотойгоор цаашид манай улсын оролцооны талаар ул суурьтай судлаж, байр сууриа тодорхойлох шаардлага тулгарч байна.

Гишүүн болж жинхлэх нь зүйтэй гэж үзэхэд ШХАБ-ын хөгжилттэй холбоотойгоор бий болсон дараах шинэ хүчин зүйл, нөхцлүүд байна. Үүнд:

1. Байгууллагын зорилго, хэтийн төлөв арай илүү тодорхой болж байна. Анх байгуулагдахад нь олон хүний таамаглаж, болгоомжилж байсанчлан ШХАБ улс төр-цэргийн эвсэл хараахан болсонгүй. Олон салбар, чиглэлд үйл ажиллагаа явуулж буй нь цаашид улам өргөжих, бодит үр ашиг авчрах боломжтой нь ажиглагдаж байна. “ШХАБ-ын 2025 он хүртэлх хөгжлийн стратеги” хэмээх баримт бичгээс тус байгууллагын цаашдын үйл

ажиллагааны талаарх гол зүйлсийг ойлгож болох юм. Тухайлбал, зорилгын тухайд тус байгууллага нь үндэстэн улсынхаас илүү дээгүүр удирдлагын бүтэц бүхий улс төр-цэргийн эвсэл, эсхүл эдийн засгийн интеграцийн бүлэглэл болохгүй гэдгээ тусгажээ.

2. Байгууллагын үйл ажиллагааны зарчим, хэм хэмжээ бүрэлдэж, механизм нь боловсронгуй болж, эрх зүйн үндэс нь бэхжиж байна. ШХАБ-ын үйл ажиллагаа нь “харилцан итгэлцэх, харилцан ашигтай, эрх тэгш хамтын ажиллагаа өрнүүлэх, хамтран хөгжих, яриа хэлэлцээний замаар маргаантай асуудлыг шийдвэрлэх, соёл иргэншлийн зөрүүтэй байдлыг хүндэтгэх, эвсэлд үл нэгдэх, үйл ажиллагаагаа аливаа нэг улсын эсрэг чиглүүлэхгүй зэрэг санааг тусгасан “Шанхайн үзэл санаа” гэж нэрлэгддэг зарчимд тулгуурладаг. Энэ үзэл санааны үндсэн дээр ШХАБ-ын хүрээнд аливаа шийдвэрийг нийтийн тохиролцооны зарчим/консенсус/-аар гаргадаг” гэдэг. Өөрөөр хэлбэл, их гүрнүүд болон жижиг орнууд яг тэнцүү эрхтэй байх нь бодит байдал дээр эргэлзээтэй хэдий ч тус байгууллагын хүрээнд “нийтийн тохиролцооны зарчим” мөрдөгддөг гэж гишүүн орнууд өөрсдөө хэлдэг.

3. ШХАБ-т манай хоёр том хөрш ОХУ, БНХАУ гол үүрэг гүйцэтгэж байна. Эдгээр хоёр улсын хоорондын гол асуудал, тухайлбал, аюулгүй байдал, цэргийн хамтын ажиллагаа, дэд бүтцийн томоохон төсөл зэрэг нь ШХАБ-ын хүрээнд яригдаж байна. Эдгээрт манай улс оролцохын тулд тус хоёр улсын голлон тэргүүлдэг ШХАБ-тай хамтран ажиллах нь чухал.

4. Бүс нутагт ШХАБ-аас өөр нөлөөтэй байгууллага байхгүй байна.

ШХАБ нь манай улсад хамгийн ойр дөт байгаа олон улсын байгууллага.

5.Энэтхэг, Пакистан жинхэнэ гишүүн болсноор тус байгууллагыг “Орос, Хятад удирддаг” шинж төрх өөрчлөгдөх юм. Ингэснээр манай улс гишүүнээр элсэх тохиолдолд хоёр хөршийн үзүүлэх нөлөө нэмэгдэнэ гэсэн болгоомжлол тодорхой хэмжээгээр багасах юм.

6.Энэтхэг, Пакистан гишүүн болсноор ажиглагчийн статусын тус байгууллага дахь ач холбогдол буурна. Ингэснээр ажиглагч хэвээр байх тохиолдолд манай улсын оролцооны үнэ цэнэ буурч, анхаарлын гадна үлдэх магадлал ихтэй.

7.ШХАБ-ын талаарх байр суурь, бодлого маань манай улсын хөрш орнууддаа хандах хандлага, тэдгээртэй харилцах бодлогын үргэлжлэл, салшгүй хэсэг болж харагддаг. Гишүүн болохоос хэт цааргалснаар хөрш орнууддаа үл итгэдэг, болгоомжилдог гэсэн ойлголт нэмэгдэх бөгөөд энэ нь хоёр хөрштэй хөгжүүлж буй харилцаанд сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Товчоор хэлэхэд ШХАБ-д элсэх хүсэлт гаргах эсэх нь хоёр хөрштэй ойртож, тулж ажиллах уу, тодорхой зайнаас харилцах уу гэдэг сонголттой шууд холбогдох болж байна. Тодорхой зайнаас үр ашигтайгаар харилцах боломж бий юу гэдгийг нухацтай бодох хэрэгтэй болов уу.

8.Хоёр хөршийнхөө байр суурийг харгалзах шаардлага улам нэмэгдэх магадлалтай. ШХАБ-ын хүрээнд өнөөг хүртэлх хугацаанд гаргасан баримт бичгүүдийн агуулгыг харахад Орос, Хятадын байр суурь, ашиг сонирхолыг тусгасан үг хэллэг цөөнгүй байдаг. Тухайлбал, 2008 оны 3 дугаар сард Төвдөд гарсан, 2009 оны 7 дугаар сард Өрөмчид гарсан үйл явдлын дараа Хятадын Засгийн газрыг дэмжсэн угтатуй мэдэгдэл гаргасан. НҮБ-ын шинэчлэлийн асуудлаарх байр суурь нь үндсэндээ БНХАУ-ын байр суурь байдаг. “Ташкентын тунхаглал”-д Өмнөд Хятадын тэнгисийн асуудлаар “маргаантай асуудлыг уг асуудалд шууд оролцогч талууд яриа хэлэлцээний замаар шийдвэрлэх ёстой, асуудлыг олон

улсжуулах, гадны хүч хөндлөнгөөс оролцохыг эсэргүүцнэ” гэж тусгасан нь ч мөн БНХАУ-ын байр суурь юм. Батлан хамгаалахын сайд нарын 2016 оны уулзалтын хэвлэлийн мэдээнд: “ОХУ-ын зэвсэгт хүчний Сири дэх олон улсын терроризмтэй тэмцэх, Сирийн ард түмэнд тусламж үзүүлэх чиглэлээрх үйл ажиллагааг өндрөөр үнэлэв” гэж тусгасан байх жишээтэй.

9.Манай улсад төдийлөн ач холбогдолгүй салбар, чиглэлд, тухайлбал, салан тусгаарлах үзэл, хэт даврах үзэлтэй тэмцэх чиглэлд байгууллагын хүрээний үйл ажиллагаанд тодорхой хэмжээгээр оролцох шаардлагатай болно.

10.ШХАБ-ын хүрээнд байгуулагдсан олон уулзалт, ажлын хэсгийн механизмд оролцох нь манай улсын төсөвт тодорхой дарамт, бэрхшээл үүсгэж болзошгүй. Өнөөгийн байдлаар ШХАБ-ын төсвийн 20,6 хувийг БНХАУ, 20,6 хувийг ОХУ, 17,6 хувийг Казахстан, 14,6 хувийг Узбекистан, 8,8 хувийг Киргизстан, 6 хувийг Тажикстан 5,9 хувийг Энэтхэг, 5,9 хувийг Пакистан гаргаж байна. ШХАБ-ын жилийн төсөв 9 сая орчим доллар гэсэн мэдээлэл байна.

Нөгөө талаас гишүүн болох хүсэлт гаргахгүй, ажиглагчаараа үлдэх нь зүйтэй гэж үзэхэд дараах хүчин зүйлүүдийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

1.Тус байгууллагын хүрээн дэх эдийн засгийн хамтын ажиллагаа нь байгууллагын бодит бололцоотой харьцуулахад чамлалттай, байгууллагын хүрээний бус хоёр талын төслүүдийн цуглуулга шинжтэй явж ирсэн гэж судлаачид шүүмжилдэг.

2.ШХАБ-ын хүрээнд манайх эдийн засгийн хамтын ажиллагааг бодитой хөгжүүлэх боломж, төлөв хомс байна. Энэ тохиолдолд Орос-Монгол-Хятадын эдийн засгийн коридор байгуулах тохиролцоог идэвхитэй хэрэгжүүлэхэд хүч анхаарлаа төвлөрүүлэх нь чухал байна. Ялангуяа эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийн хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн жагсаалтын 1-15 дахь төслүүдийг тэргүүн ээлжийн зорилт болгон бодитойгоор хэрэгжүүлэх нь “Нэг

бүс, нэг зам” стратегид манай улсыг холбох ганц зөв, ирээдүйтэй чиглэл гэж үзнэ. Мөн ЕАЭЗХ-той тодорхой ярилцан эхний ээлжинд тус байгууллагад гишүүнчлэлтэй болохыг зорих нь ШХАБ-д элсэхээс илүү бодит ач холбогдолтой, нэг улсаас хэт хамааралт байдлыг багасгах зорилгод нийцэх, манай бараа бүтээгдэхүүнд шинэ зах зээл нээж өгөх зэрэг олон талын ашигтай байх юм.

2.Гишүүнээр элссэнээр хоёр хөрш орнуудын манайд үзүүлэх нөлөө улам ихсэнэ, “гуравдагч хөрш”-ийн бодлоготой зөрчилдөнө гэсэн болгоомжлол бас байгаа. ШХАБ-ын баримт бичиг, мэдэгдлүүдэд Орос, Хятадын байр суурь, ашиг сонирхол тусгасан үг хэллэгүүд олонтаа тохиолддог. Өнөөгийн олон улсын харилцаа ээдрээтэй, хурцадмал байгаа нь үүнийг харгалзан үзэх ёстой нөхцөл мөн.

2.ОХУ, БНХАУ-ын ашиг сонирхлын зөрчил, Энэтхэг, Пакистан улсууд ШХАБ-т нэгдсэнээр тэдгээрийн хоорондын зөрчил нь байгууллагын шийдвэр гаргах, тохиролцоонд хүрэх боломжийг багасгахад хүргэх, улмаар ШХАБ-ын цаашдын хөгжилд урьдчилан тооцоолох боломжгүй нөлөө үзүүлж болох талтай. Тус байгууллагын гишүүн орнуудын нийгэм улс төр, соёл иргэншлийн хэт ялгавартай, эрс тэс байдлын улмаас цаашдын интеграцын процесс түргэн шуурхай, амар хялбар байхгүй гэж үзэх явдал ч байна.

3.Тус байгууллагад янз бүрийн улс төрийн тогтолцоо, төрийн байгууламжтай орнууд нэгдсэн. Ийм ч учраас нэгдмэл үнэт зүйл, зарчим хэм хэмжээ нь чухам юу болох нь эдүгээ хүртэл төдийлөн тодорхойгүй явж ирсэн. Европын холбооны хувьд ардчилал зах зээл, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх явдлыг нийтлэг үнэт зүйл, зарчим хэм хэмжээ гэж бүх гишүүн орон хүлээн зөвшөөрдөг. 2015 онд баталсан “2015 он хүртэлх ШХАБ-ын хөгжлийн стратегид байгууллагын зарчим, үнэт зүйл нь ШХАБ-ын гишүүн орнууд тусгаар тогтнол, аюулгүй байдал, хөгжил болон амьдралын бусад чухал асуудлаар бие биедээ тусалж

дэмжих явдал бөгөөд гишүүн орны эсрэг чиглэсэн аливаа эвсэл холбоо, байгууллагад элсэхгүй гэж заажээ. ШХАБ-ын хамтын ажиллагааны хүрээ хэт өргөн, өөрөөр хэлбэл тодорхой биш, үйл ажиллагааны чиглэл, хамтран ажиллах хүрээ тодорхой болж цэгцэрч амжаагүй байна.

4. Манай улс гишүүнчлэлийн асуудалд болгоомжлонгүй хандаж ирсэн бас нэг шалтгаан бий. Тэр нь ШХАБ-ын үйл ажиллагаа эхний үед аюулгүй байдлын чиглэл, ялангуяа “гурван гай” гэгддэг алан хядлага, салан тусгаарлах үзэл, хэт даврах үзэлтэй тэмцэх чиглэлд төвлөрч байсан явдал юм. Өөрөөр хэлбэл, энэ чиглэлд хамтран ажиллах онцгой шаардлага манай улсад байхгүй гэж үздэг.

Цаашид аль ч хувилбарыг сонгосноос үл хамаарч ШХАБ-ын үйл ажиллагаан дахь манай оролцоог нэмэгдүүлэн эрчимжүүлэх, тодорхой чиглэл, зорилго тавьж ажиллах, ШХАБ-ын талаарх бүх талын судалгааг хийх, баримтлах бодлого, чиглэлийг нарийвчлан боловсруулах, ШХАБ-д элсэх, эсэх асуудлаар дотооддоо нэгдмэл ойлголт, консенсус бий болгохыг аль болох эрмэлзэх, ШХАБ-д элсэхэд манай талаас тавих нөхцөл, шаардлагыг эртлэн тодорхойлох, үүнийг хэрэгжүүлэх тодорхой алхмууд, арга тактикийг боловсруулах нь зүйтэй гэж үзнэ. Юуны өмнө дараах арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй. Үүнд:

1. ШХАБ-ын дээд хэмжээний уулзалтуудаас гадна салбарын сайд нарын уулзалт арга хэмжээ болон ШХАБ-ын хүрээнд зохион байгуулагдаж буй бусад үйл явдал, арга хэмжээнүүдэд манай оролцоог нэмэгдүүлэх

2. ШХАБ-д элсэхийн тулд заавал нэгдэх ёстой баримт бичгүүдийг үл суурьтай судлаж, манай улсын эрх ашигт зарчмын хувьд харшлах заалт байгаа эсэхийг тодорхойлох, тэдгээр баримт бичгүүд нь манай улсын эдүгээ нэгдэн орсон олон улсын эрх зүйн баримт бичгүүдтэй зөрчилдөж буй эсэхийг сайтар судлах, ажиглагчаар үлдсэн тохиолдолд ШХАБ-ын хүрээнд байгуулагдсан гэрээ, хэлэлцээрүүд дотроос манай

улсын хувьд ач холбогдолтой зарим гэрээ, хэлэлцээрт нэгдэх боломжийг судлах.

3. АНУ зэрэг зарим гуравдагч хөршүүд маань ШХАБ-ыг тэдгээрийн эсрэг чиглэсэн ОХУ, Хятадын сэдсэн байгууллага гэж үздэг нь нууц биш. Бид ШХАБ-т элсэхээр болсон тохиолдолд гуравдагч хөршүүддээ манай хандлага, байр сууриа сайтар тайлбарлаж ойлгуулах нь зүйтэй.

4. ШХАБ-ын талаар баримтлах чиглэлийг нарийвчлан боловсруулж, дээд байгууллагаар батлуулан мөрдөж ажиллах. ШХАБ-ын үйл ажиллагаанд оролцох чиглэлийг тэргүүлэх чиглэл (эдийн засгийн хамтын ажиллагаа, тухайлбал эрчим хүч, дэд бүтэц, дамжин өнгөрөх тээвэр, хөдөө аж ахуй), идэвхтэй оролцох чиглэл (боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүл мэнд, байгаль орчин, гамшгийн менежмент), зохих хэлбэрээр оролцох чиглэл (алан хядлага, хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх) гэж ангилан, тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаанд нь манай холбогдох байгууллагууд идэвхтэй оролцох хэрэгтэй.

5. ШХАБ-ын хүрээнд хоёр болон олон талын шугамаар хэрэгжүүлж болох тодорхой төсөл, хөтөлбөрийг үндэслэл, тооцоо сайтай бэлтгэж санал болгох.

6. Тус байгууллагын талаарх судалгааг эрс гүнзгийрүүлэх, шаардлагатай дотоод зохион байгуулалт, оролцооны механизмыг бүрдүүлж эхлэх. Үүний зэрэгцээ орос, хятад хэлтэй боловсон хүчнийг засгийн газрын бүх байгууллагын хэмжээнд бэлтгэхэд илүү анхаарах.

7. Гишүүн болсон ч, ажиглагч хэвээр үлдсэн ч цаашид ШХАБ дахь оролцоог илүү үр дүнтэй болгоход төрийн байгууллагуудаас гадна хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллагуудын үүрэг чухал юм. ШХАБ-ын хүрээнд дэх засгийн газрын бус 3 бүтэц болох Ажил хэргийн зөвлөл, Банкны нэгдэл, “ШХАБ-ын форум”-ын үйл ажиллагаанд манай холбогдох байгууллагуудыг тогтмол, идэвхтэй оролцуулдаг байх нь Монгол Улсын оролцоог идэвхжүүлэх, үр дүнг сайжруулахад тустай. ШХАБ-ын гишүүн орнуудын эрдэмтэн судлаачид байгууллагын үйл

ажиллагааны талаар санал солилцож, төр, засгийн байгууллагууддаа санал, зөвлөмж дэвшүүлдэг гол суваг болох “ШХАБ-ын форум”-ын үйл ажиллагаанд эрдэм шинжилгээний байгууллагуудыг идэвхтэй оролцуулах, цаашид эрдэм шинжилгээний 1-2 байгууллагуудыг түшиглэн ШХАБ судлалын төв юм уу ШХАБ-ын асуудлаарх албан бус зөвлөл байгуулж ажиллах нь зөв болов уу. Ажил хэргийн зөвлөлийн үйл ажиллагаанд МҮХАҮТ оролцож ирснийг илүү тогтмолжуулах, байнгын шинжтэй болгох хэрэгтэй. Мөн Банкны нэгдлийн үйл ажиллагаанд манай банкуудыг зохистой хэлбэрээр оролцуулах шаардлагатай.

Эцэст нь өнөөгийн шатанд ШХАБ-д гишүүнээр элсэх, эсвэл ажиглагчийн статусаа хэвээр хадгалахын аль нь зүйтэй болох талаар тус судалгааны хэлэлцүүлэгт оролцсон эрдэмтэн, судлаачид, олон улсын харилцааны мэргэжилтнүүдийн хэлсэн үг, байр сууринаас үзэхэд тэдгээрийн цөөнхи нь ШХАБ-д гишүүн болох хэрэгтэй гэсэн байр суурьтай байсан бол олонхи нь ажиглагчийн байр сууриа хэвээр хадгалах, чингэхдээ аль болох идэвхитэй ажиглагч байхын чухлыг онцлон тэмдэглэж байв.

Өнөөгийн бодит байдлаас үзэхэд Монгол Улс ШХАБ-д гишүүнээр элслээ гэж бодоход манай худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа Төв Ази, Баруун Ази, арабын ертөнцтэй учиргүй их өсч нэмэгдээд явчина гэж үзэх үндэс огт харагдахгүй байна. Эдгээр орны эдийн засгийн хөгжлийн түвшин, гадаад худалдааны бүтэц зэрэг нь манай сонирхлыг төдийлэн татахуйц бус бөгөөд 2017 оны байдлаар манай экспортод эдгээр орны эзлэх хэмжээ 0,2 хувь байна. Харин Зүүн Хойт Азийн орнууд манай экспортод өнгөрсөн оны байдлаар 85 хувийг, нийт худалдаанд 69,3 хувийг эзэлж байна¹. Үүнээс үзвэл манай гадаад харилцаа, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа юуны өмнө аль бүс нутагт хандан төвлөрч буй, цаашдын төлөв нь ч ямар байх нь тодорхой гэж үзнэ.

1 National Statistics Office of Mongolia, 2018



Д.Баярхүү

Олон улсын харилцааны судлаач-проф

ОРОС ШХАБ-Д

Би Орос орныг сайн судалдаг. Мэдээллээс хоцрохгүйг хичээдэг. Оросоо сайн таньж мэдэж байж түүнтэй зөв харилцана гэдгийг ч мэдэрдэг. “Монгол-Зөвлөлтийн найрамдал” гэх сэтгэлгээг бүрэн гээх ёстойг ч сайн мэднэ. Судлах тусам гэгээтэй, эерэг гэхээсээ бүрхэг, хэлж таашгүй, бүр бүслэлтийн байдалд (Монгол биш л дээ!) Орос маань өөрийгөө шахаад оруулчихав уу гэлтэй үйл явдлууд өрнөсөөр буйг бид харж байна. Үүнийг ШХАБ-ын талаархи байр сууринаас нь эрж хайж, үнэлэлт дүгнэлт өгөхийг хичээе.

«Шанхайн тав» нэрээр хилийн асуудал шийдвэрлэх, аюулгүй байдлын салбарт хамтын ажиллагаа өрнүүлэх нөхцлөөр ШХАБ анхлан байгуулагдсан. СССР тарсны дараа Орос ба Төв Азийн шинэ улсуудтай Хятад асуудлаа зохицуулах шаардлага тэр үед тулгарсан. Үүний сацуу афганы талибуудын аюул занал Төв Азийн («Шанхайн тав»-ын хүрээнд гэсэн үг) хувьд ноцтой болж ирсэн учраас цааш нь тэлж өргөжүүлэн бүс нутгийн байгууллага болгон томруулахаас өөр арга байгаагүй. Үнэндээ Афганистанаас учрах аюулын өмнө Төв Азийн хэдэн улс хүчгүйтэх нөхцөл бүрдсэн байв. 2001 онд «Шанхайн тав»-д Узбекистан нэмэгдэж орсноор ШХАБ хэмээх бүс нутгийн нэгдэл буй болж, 2005 онд Энэтхэг, Пакистан тус байгууллагын ажиглагч болж, 2014 онд Энэтхэг нь жинхлэх өргөдөлөө түрүүлж өгчээ. Ингээд дараа жил нь гишүүнээр элсэж, жинхлэх асуудал нь 38 төрлийн баримт

бичигт гарын үсэг зурснаар 2016 онд өндөрлөж, харин 2017.06.09-нд бүрэн эрхт гишүүн болжээ. Пакистан ч мөн ийм зам туулжээ.

Орос, Хятад хоёр бол ШХАБ-ын гол зонхилох гишүүд бөгөөд тэгээд ч ШХАБ-ын албан ёсны хэл нь орос ба хятад хэл. ШХАБ-ын нэг чухал гол чиглэл бол терроризмын эсрэг тэмцэх бүс нутгийн бүтэц нь юм. Тэр бүтэц нь «гурван хорт хүчин»-тэй тэмцэнэ: терроризм, сепаратизм, экстремизм. Мэдээлэл солилцохоос эхлэн терроризмын эсрэг хамтарсан хээрийн сургууль хийх, энэ тэмцэл дэх тэргүүн туршлагаа солилцох явдал үүнд орно. Эдүгээ «Лалын улс» гэх радикал бүлгийн аюул занал тархаж буйтай холбогдуулан аюулгүй байдлын салбарт ШХАБ онцгой анхаарах шаардлага тулгарч байна. Учир нь терроризмын эсрэг тэмцэх ШХАБ-ын бүс нутаг бол Төв Ази болно.

Яг энэ өнцгөөс Орос ШХАБ-д ажиллаж байх шиг. Өрнө дахинаас олон удаагийн санкц тавиулаад удсан, Европ болон G-8-аасаа шахагдсан Оросын хувьд ШХАБ бол нэг ёсны холбоотны эвсэл, эвслийг Оросын үзэмжээр өргөжүүлээд тэлээд байх нь тэдний ашиг сонирхол. Афганистан, Беларусь, Иран болон Монгол нь тус байгууллагад ажиглагчийн статустай байгаа ба энэ 4-өөс жинхэнэ гишүүн нэмж элсүүлэх нь Оросын зорилго. “Ираныг ШХАБ-д авахад ямар ч саад байхгүй, тийм саадыг олж харагүй байна” хэмээн Путин 2016 онд Ташкентын саммит дээр ярьсныг бид мэднэ. “Цөмийн үйлдвэртэй холбогдох асуудлаа

Иран нь шийдүүлж, НУБ хоригоо цуцалсан тул одоо Тегеранаас ирүүлсэн өргөдлийг нааштайгаар хэлэлцэж шийдвэрлэхэд ямар ч саад тотгор байхгүй боллоо” хэмээн Путин тэгэхэд хэлж байсансан. Харин ШХАБ хариуцсан түүний тусгай төлөөлөгч Бахтиер Хакимовын хэлснээр бол Шанхайн байгууллагын гишүүн орнууд Ираныг байгууллагадаа элсүүлэх талаар тохиролцоонд хүрээгүй, зарчмын хувьд түдгэлзэх явдал байхгүй, гэвч энэ үйл явцыг хэрэгжүүлэхэд техникийн хувьд элдэв нюанс байна гэжээ.

Туркийг ШХАБ-д авъя хэмээн зоригтой дуугарах улс төрч хараахан тодроогүй. Харин оросын албан бус сувгийн хүрээнд энэ талаар элдэв яриа хөөрөө чамгүй өрнөсөн, өрнөж байна. Астанад энэ тухай ил ярилцаагүй ч Турк тийшээ хандаж буйг илтгэх эшлэл авъя.

Ерөнхийлөгч Режеп Тайип Эрдоганы 2016 онд хэлсэн үг байна: Европын Холбоонд элсэн хэмээн Турк горьдож суух өнгөрлөө, тэгэхийн оронд ШХАБ-ын нэг хэсэг болж болох юм. Туркчууд бид тайвшрах ёстой. Ямар ч үнээр хамаагүй Европын Холбоо гэж ярихаа болих хэрэгтэй. Тэгэж ярихын оронд яагаад Турк нь “Шанхайн тав”-д нийлж нэгдэж болдоггүй юм бэ? Би энэ тухай Путин, Назарбаев нарт хэлсэн. Тэд чинь “Шанхайн тав”-д байгаа шүү дээ гэжээ. 2013 онд Турк нь ШХАБ-ын яриа хэлэлцээний түншийн статустай болсон, тэгснээрээ өөрсдийнх нь ярьж байгаагаар Шанхайн эвслийн гишүүдтэй ижил хувь заяатай, тийм хувь заяаг хуваалцагч болсон аж.

ШХАБ-ыг сонирхогч Сирийн тухай энд маргаж үл болно. Ажиглагч гишүүн болохоор өргөдлөө өргөн барьсан гэдэгт Сири, Египет, Израиль, Бангладеш гэсэн 4 улсын нэр цохиж яваа. Хамгийн магадлалтай нь буюу ОХУ-аас ямар ч эргэлзээгүй дэмжлэг авах нь Сири юм.

Хэрэв ШХАБ-д Иран, Афганистан жинхэлж, цаашлаад

одоо хүслээ илэрхийлдэг болсон Сири оролцож эхэлбэл ШХАБ нь лалын ертөнц дэх эцэс төгсгөлгүй дайн тэмцлийн арбитрын шүүх болж хувирна. Тэр бол Монголын язгуур эрх ашгаас дэндүү алсуур үйл явдал болно.

ШХАБ-ын хүрээнд Хятад, Энэтхэг хоёр зөрчилдөх, Энэтхэг нь элдэв бойкот хийх, Энэтхэг, Пакистан хоёр мөргөлдөх, Сирид АНУ ба түүний холбоотнууд Орос, Ирантай мөргөлдөх тохиолдолд Монгол Улс төвийг сахих байр суурин дээр байхаас өөр гарцгүй.

ШХАБ-д гишүүнээр элсүүлэхийг Орос шахсан, уриалсан, лоббидсон, лоббидож эхэлсэн гэдэгт Иран, Турк хоёрыг оруулж нэрлэлээ. Цаана нь Монголыг ШХАБ-д жинхлүүлэхийг XXI зууны эхнээс л лоббидсоныг нэмж хэлмээр

байна. 2001 оны нэгдүгээр сард Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди Энэтхэгт төрийн айлчлал хийхэд гар бие оролцож явсны хувьд би (Би тэр үед Дели дэх ЭСЯ-нд Зөвлөх байсан) нэг яриаг хэзээ ч мартдаггүй юм. Танай улс тэр “Шанхайн тав”-даа нэгдэж орж болдоггүй юм уу, яагаад болохгүй гэж хэмээн Монголын Төрийн тэргүүнтэй хэлэлцээ хийж суусан БНЭУ-ын Ерөнхий сайд А.Б.Важпаи шууд хэлж билээ. Өмнөхөн нь ОХУ-ын Ерөнхийлөгч Путин Энэтхэгт айлчлаад Важпаитай хэлэлцээ хийгээд буцсан, би хувьдаа Путины дайсан үг болов уу хэмээн боддог.

Энэтхэг, Пакистан хоёр ажиглагч байснаа элсчихлээ, манайх хоцорчихлоо гэх сэтгэхүй Монголд мэр сэр цухалздаг.

Монгол Улс хэрхэх вэ гэдэгт айхтар хариулт хайгаад тархиа гашилгаад байх нь арай эртдэх мэт. ШХАБ нь ийнхүү бүс нутгийн улс төрийн байгууллага байгаа нөхцөлд Монгол Улс идэвхтэй ажиглагчаар оролцож байр сууриа илэрхийлж, ШХАБ-ын олон уулзалт хурлуудад идэвхтэй оролцоод явахад ямар ч саад байхгүй гэж үзэж байна. Эдийн засгийн асуудлаар хамтран ажиллана гэж яригддаг, хэрэгждэггүй, хэлбэр төдий байгаа бол одоогоор идэвхтэй ажиглагчаараа байх нь зөв болов уу. Хэрэв Европын Холбоо, АСЕАН шиг эдийн засгийн маш том эвсэл Евразид бүрдэх аваас Монгол юу боллоо гэж хойш суух билээ дээ?

“НЭГ БҮС, НЭГ ЗАМ”-ЫН БЭЛЧИРТ

Хятад ШХАБ-ыг хэрхэн хардаг, тэр нь эдийн засгийн ямар зорилготой вэ? Ерөөсөө л ШХАБ бол интеграцын бүтэц, “Нэг бүс, нэг зам” бодлогыг нь урагшлуулах интеграцын бүтэц. Дэд бүтцийн төслүүд нь шил шилээ харан ярайж байна. Евразийн их тивд Хятад нь томхон төв болох бүх нөхцлийг нь Шанхайн байгууллага хангаж өгөх учиртай. Юуны төлөө “Шанхайн” гэж овоглосон билээ. ШХАБ-ын гишүүд нь Хятадын оролцоотой бүтээн байгуулсан зам, төмөр зам, газрын тос, байгалийн хийн хоолойгоор Хятадтай шууд холбогдох учиртай. ШХАБ өргөжин тэлээд л, шинэ шинэ гишүүн элсээд л байвал ШХАБ дотор Хятадын байр суурь бэхжээд байх учиртай. ШХАБ-аар дамжаад Хятад нь Өмнөд Ази руу нэвчиж бэхжинэ. Тэнд бүр хүчтэй байр суурьтай болно. Үндсэндээ Хятадаас Европ хүртэлх өргөн уудам нутаг дэвсгэрт Хятад нь эдийн засгийн оролцоогоо тэлэх

төлөвлөгөөтэй. Энэ бол БНХАУ-ын байр суурь ба зорилго.

“Торгоны замын эдийн засгийн бүслүүр” гэсэн нэрээр Си Жиньпиний санаачилга 2013 оны 9 дүгээр сард Астанад Назарбаевын нэрэмжит их сургуульд тавьсан айлтгалд нь дурдагдсан. Дэлхийд тэгтлээ өндөр авсан асуудал босч ирнэ чинээ тэр үедээ хэн ч, хаана ч төсөөлөөгүй. Зорилго нь Евразийн худалдаа-эдийн засгийн нэгдмэл орон зай, тив дамжсан тээврийн коридор буй болгох. МЭӨ II зуунаас манай эриний XV зууны үеүдэд Хятадыг Төв Азиар дамжуулан Европтой жингийн хөсгөөр холбосон эртний торгоны замын нэрээр уг санаачилгаа нэрлэжээ. Энэ лут зорилгодоо хүрэх 5 үндсэн зорилгоо хятад нөхөд ингэж томъёолсон: 1) Бүс нутгийн эдийн засгийн интеграцыг эрчимжүүлэх; 2) Транс-Азийн тээврийн нэгдсэн дэд бүтэц байгуулах; 3) Хөрөнгө оруулалт ба худалдаанд тохиолддог барьер саадыг гэтэлгэх; 4) Үндэсний

валютуудыг бэхжүүлэх; 5) Хүмүүнлэгийн салбарт хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх гэжээ.

Тэртээ 5 жилийн өмнө л энэхүү бүслүүрт 67 улс орон буюу дэлхийн хүн амын 63 хувь нь багтана, санаачилгаа төсөл болгон хэрэгжүүлэх хугацаагаа 30 жил байхаар заажээ.

Хар ухаанаар төсөөл л дөө. Хятадаас Европ руу ачаа бараа зөөвөрлөх хугацааг эрс багасгана. Эдүгээ контейнерын ачаа далайгаар усан онгоцоор 45-60 хоног зарцуулан байж Европт хүрдэг бол төсөл хэрэгжсэнээр 10 хоногтоо амжуулна. Тээврийн харилцаа өрнөөд ирэхтэй зэрэг гаалийн хамтын ажиллагаа дагаж бужигнана, санхүүгийн операц тэлнэ, санхүү- дэд бүтцийн институц ажилтай, орлоготой болж, ажлын байр эрс нэмэгдэнэ, соёл, шинжлэх ухаан, хэвлэл мэдээлэл, залуучуудын солилцоо гээд салбарлаад олон улсын лут хамтын ажиллагаа өрнөх болно хэмээн хятадын тал тооцоолжээ.

“Торгоны замын эдийн засгийн бүслүүр”-ийн дагуухи төмөр замын маршрутыг одоогоор гурван коридор (умард, төв, өмнөд) байхаар төсөөлж байна. Харамсалтай нь Улаанбаатар-Бээжингийн маршрут энд багтаагүй байгаа. Умард коридорын маршрут Хятадаас барууншалаад Казахстан, Орос, Балтийн тэнгис, тэндээсээ Белорусс, Польш, Герман, Нидерланд гэж салбарлах; төв коридор нь Хятадын Шанхай, Ляньюньган боомтоос барууншалаад Төв Ази хүрэх (Киргизстан, Узбекистан, Туркменистан), тэндээсээ Иран, Турк (Босфорын хоолойгоор туннелиэр) хүрээд цаашаа Балканы хойг, бүр цаашилбал Францын баруун эрэг хүрэх; өмнөд маршрут нь Хятадаас чанх урагшаа Бангладеш, Энэтхэг, Пакистан хүрэх хэмээн тооцоолжээ. Гэхдээ 30 жилдээ бүтээн байгуулах төлөвлөгөө шүү дээ.

Ноён Си Жиньпин Евразийн хуурай газрын торгоны замын санаачилгаа дэвшүүлчихээд тун удалгүй XXI зууны далайн торгоны зам гэх төслөө зарлажээ. Астанад айлдвараа тавьсанаас хойш ердөө сарын дараа 2013 ны 10 дугаар сард Индонезид айлчлах үеэрээ энэ тухай ярьсан байгаа юм. Далайн худалдааг хөгжүүлэх концепц гэж үзэж болно. Хятадын Фузянь мужийн Фужоу хотоос гараагаа эхлээд Гуандун муж, Хайнань арал, улмаар Малаккийн хоолой (Малайз-Индонез), тэндээсээ Энэтхэгийн далай руу нэвтрээд, Африкийн эвэр (Кени) хүрээд, тэндээсээ Улаан тэнгис, Суэцийн суваг, Газар дундын тэнгис хүрэх эхний нэг маршрутыг төсөөлж болж байна. Өөр нэг чиглэл нь Хятадын боомтуудаас Номхон далай руу чиглээд Өмнөд Номхон далайн арал, улс, тив рүү хүрэх тухай төлөвлөжээ. Хуурай газрын ба далайн торгоны замын энэ лут төслөө “Нэг бүс -Нэг зам” (товчлоод “Бүс ба Зам”) хэмээн нэрлэж байгаа билээ.

Энд би Монгол руугаа татаж жишээ, гарц хайя. “Нэг бүс-Нэг зам”-ын олон улсын хамтын

ажиллагааны дээд хэмжээний уулзалтыг 2017.05.14-нд Бээжин хотноо зохион байгуулсан. БНХАУ-ын дарга Си Жиньпин нээлтийн ёслолд оролцон гол сэдвээр үг хэлсэн. Үүнд олон улсын хамтын ажиллагааг эрчимжүүлэх замаар “Нэг бүс-Нэг зам”-ыг хамтран байгуулж, хамтран ашиг хүртэж, хамтран хөгжье хэмээн уриалсан (гурван “хамтран”) ба уг хурлын уриа лоозон ч яг ийм гарчигтай байсан. Дээд хэмжээний тэрхүү уулзалтад 29 улс орны төр, засгийн тэргүүн (тэдэн дотор Монгол Улсын Ерөнхий сайд), НҮБ, Дэлхийн Банк, ОУВС зэрэг олон улсын 70 гаруй байгууллага, форумын төлөөлөгчид, тэрчлэн 100 гаруй улс орны албаны ба худалдааны төлөөлөгчид оролцсоныг эргэж санууштай.

“Нэг бүс-Нэг зам”-ын тухай ноён Си Жиньпиний 2013 онд дэвшүүлсэн нөгөө санаачилгуудыг хэрэгжүүлэх хүрээнд анх удаа саммит зохион байгуулсан нь энэ байсан ба хурлын түлхүүр хоёр үг нь “Хамтран ажиллах”, “Хамтдаа ашиг хүртэх” гэсэн үгс, эл сэдвийн хүрээнд 1) Бодлогын харилцан холболт; 2) Зам харилцааны харилцан нэвтрэлт; 3) Худалдааны шуурхай нэвтрэлт; 4) Валютын солилцоо; 5) Иргэдийн сэргэлт санааны эв нэгдэл, энэ 5-ыг эрчимжүүлэх тухай хэлэлцсэн. Эдүгээ олон улсын харилцаанд АПЕК, АРФ, БРИКС, ШХАБ гэдэг шиг “Нэг бүс-Нэг зам”-ын олон улсын хамтын ажиллагааны форум гэх олон улсын Засгийн газар хоорондын институц төлөвшиж эхэлснийг бид харж байна.

“Нэг бүс-Нэг зам”-ын олон улсын хамтын ажиллагааны дээд хэмжээний тэрхүү уулзалтаас хойш Хятадын think tank-судалгааны гол хүрээлэн, нэртэй судлаачид дээрхи 5 нэвтрэлтийн итгэлцүүр, шалгуур гэгчийг гаргаж ирсэн. Дээд хэмжээний уулзалтаар ярилцсан 5 холболтыг ингэж томъёолжээ. Үүнд 1) Улс төрийн ойлголцол; 2) Дэд бүтцийн холболт; 3) Худалдааны чөлөөт

байдал; 4) Санхүүгийн урсгал; 5) Иргэдийн харилцаа. Чингээд эл 5 шалгуураа “Бүс ба зам” дагуухи гадаад улс орнуудынхаа байр байдал, хөгжил дэвшил, хөгжлийн хандлагатай холбон авч үзэж байна.

Үүний тулд 2017 оны сүүлчийн байдлаар “Бүс ба зам” дагуухи гадаад 63 улс орныг судлаж нягтлан эрэмбэлжээ. Ингэж эрэмбэлэхдээ 4 ангилал хийж. Үүнд 1. Чөлөөтэй нэвтрэх орнууд; 2. Сайн үзүүлэлттэй орнууд; 3. Хүч нөөц бүхий орнууд; 4. Сул дорой орнууд гэж. Ийнхүү 4 ангилалд улс орнуудыг эрэмбэлэхдээ оноогоор дүгнэхийг зорьжээ. Таван нэвтрэлт ба холболт тутамд нь нэг бүр 10 оноо цуглуулах ёстой гэж үзвэл нэг улс 50 оноотой байж гэмээнэ дээгүүрт шалгарах учиртай аж. Хэрэв 50 оноо авч чадвал Хятадын энэ лут төслийн идэвхтэй, итгэлтэй түнш байж чадна гэсэн үг болно.

Монгол Улс нь 2017 оны сүүлчийн байдлаар 37.88 оноо бүхий $(9.06+4.57+7.88+8.24+7.63=37.88)$ дээрээсээ 7 дугаар байрт бичигдсэн нь 63 улс дотроо чамлагдахааргүй өндөр үзүүлэлтийг хангачихсан гэсэн үг юм. Тэгэхлээр манай улс ийм гайгүй сайн үнэлгээ ба бэлэн хөрсөн дээрээ бизнесийн хамтын ажиллагаагаа хурдан түргэн хөгжүүлж, гурван улсын эдийн засгийн хонгилын ажлаа уялдуулах талаар чармайлт гаргах нь зөв биз ээ.

Ийм гайгүй сайн үнэлгээ авах өөр шалтгаан ч манайд бий. 2014 онд бид хариу санал дэвшүүлсэн. Түүнийг “Талын зам” төсөл гэж нэрлэсэн. Тэр нь Ази-Европыг холбосон 5 суваг буюу авто зам, төмөр зам, газрын тос болон хийн хоолой, цахилгаан дамжуулах шугам байгуулах, түүгээр урсах транзит тээврийн орлого, бусад дагалдах бүтээн байгуулалтын орлогоор эдийн засгийн үсрэнгүй хөгжилд хүрэх зорилготой Монгол Улсын санаачилга билээ. Тэр “5”-аа “9” болгож өргөжүүлсэн санал ч манай талаас боловсруулсныг эргэж санууштай.



Д.Уламбаяр

ХИС-ийн Олон улсын харилцаа, нийгэм судлалын сургуулийн захирал, Др.проф.

ОЛОН ТҮЙЛТ ДЭЛХИЙН ШИНЭ ДЭГ ТОГТОЛЦОО ТӨЛӨВШИХ ҮЙЛ ЯВЦ БА МОНГОЛ УЛС

Дэлхийн шинэ дэг тогтолцоо хэмээх категори улс төрийн шинжлэх ухаан, олон улсын харилцаа, геополитикийн үндсэн ухагдахуунуудын нэг мөн билээ. Энэхүү улс төрийн нэр томъёо үүсэл гарлын хувьд 1776 онд буй болсон АНУ-ын Төрийн Их тамганы дардас дээр латин хэлээр «ANNUIT COEPTIS: NOVUS ORDO SECLORUM» гэж бичсэн нь “Эрин үеийн шинэ дэг журмыг Тунхаглан зарлах нь” гэснээс үүдэлтэй. 1935 онд анх гүйлгээнд гарсан АНУ-ын нэг долларын шинэ дэвсгэртийн ар талын нүүрэнд дээрх тамгын дардас хэвлэгдэн гарснаас хойш үргэлжлэн хэвлэгдсээр өнөөг хүрч иржээ.

XX зууны түүхийн огцом өөрчлөлтүүд, түүнтэй гүн гүнзгий холбоотой улс төрийн сэтгэлгээ болон орчин үеийн үеийн олон улсын харилцааны онолын хөгжилтэй уялдан дэлхийн шинэ дэг тогтолцоо хэмээх нэр томъёо олон улсын харилцааны үзэл баримтлалын шинжтэй цогц ойлголт болон гарч ирсэн. Дурьдсан ухагдахууны мөн чанар нь эмх замраагүй, хуваагдмал, олон янз, үндэсний явцуу үзэл баримтлалд суурилсан хуучин олон улсын харилцааг



хүний эрх, эрх чөлөө, ардчилал, зах зээлийн эдийн засаг, олон улсын эрхзүйн хэм хэмжээнд тулгуурлан илүү зохистой глобал засаглалаар илбэн тохинуулах замаар өнөөгийн дэлхий ертөнцийг өөрчлөн байгуулах тухай асуудал юм.

Эдүгээ нэгд, Харилцан шалтгаалцал, даяаршлын үйл явц нийгмийн бүхий л хүрээг хамарч, гадаад, дотоод орчин маш хурдан өөрчлөгдөж, тиймээс ойрх ирээдүйн төлөв байдлыг ч урьдчилан төсөөлөх боломж тун бүрхэг байгаа нь өнөөгийн олон улсын харилцааны үндсэн шинж болов.

Хоёрт, Олон улсын харилцаа, геополитикийн орчинд урьдчилан таамаглаж болохуйц тогтвортой нөхцөл байдлыг урт хугацаанд хадгалах явдал

тулгамдсан асуудал болсоор байна.

Гуравт, Хүчний тэнцвэрийг барихаас гадна ашиг сонирхолын тэнцвэрийг барих гэдэг маш чухал болов. Ухаалаг хүч буюу smart power бодлого баримтлах нь тэнцвэрийг хүч буюу power of balance-ыг тогтоох чухал эх сурвалж юм.

Дөрөвт, Төв рүү тэмүүлэх, төвөөс зугтаах хүчний аль аль нь үйлчилж буй даяаршлын эрин үед олон улсын харилцааны шинэ дэг тогтолцоо төлөвших үйл явцын төгсгөлийг төсөөлөх боломж тун бүрхэг байгаа зэрэг санал, дүгнэлтүүд юм. АНУ-ын шинэ ерөнхийлөгчийн гадаад, дотоод бодлогын шинэ параметр, Brexit-ийн үйл явц, Европын интеграцийн сорилт, ШХАБ, ЕврАзийн эдийн засгийн холбоо,

Торгоны их замын мега төслийн өргөжих үйл явц, Солонгосын хойгийн хурцадмал байдал үүний тод илрэл юм.

Тавд, Коммунизм нуран унаснаас хойш 1990-ээд онд АНУ дэлхий дээр жолоодогчийн үүрэг гүйцэтгэх тухай үзэл санаа бодлогын шинж чанартай болж байгаад ихээхэн эгдүүцэж энэ тухай судлаачид, улс төрийн тоймчид (ОХУ, лалын ертөнц) онцлон тэмдэглэж байв. Дээрхийг зарим улс гүрэн ганцаараа жанжлах гэсэн эрмэлзлэл гэж ч шүүмжилж (Хятад) байв. Хүйтэн дайнд ялалт байгуулсандаа эрэмшсэн АНУ, түүний холбоотнууд дэлхий дахинд хүний эрх, эрх чөлөө, ардчилалыг сэргээн баталгаажуулах, чөлөөт зах зээлийн эдийн засгийн харилцааг түгээн дэлгэрүүлэх тухай зааж сургаж байв.

2001 оны 9 дүгээр сарын 11-ний үйл явдлын дараа АНУ-ын тэргүүлэх оройлолтой (Pax Americana or American Primacy) байсан олон улсын харилцааны нэг туйлт (unipolarity) дэг тогтолцоо төгсгөл болох үе шат эхэлсэн тухай судлаачид тэмдэглэж эхэлсэн.

Эдүгээ улс орнуудын өмнө *нэгд*, дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлд дасан зохицох, *хоёрт*, даяаршиж буй дижитал ертөнцөд дасан зохицохоос гадна *гуравт*, олон улсын харилцааны олон туйлт шинэ дэг тогтолцоо төлөвших үйл явцад ч нэгэн адил хэрхэн дасан зохицох тухай асуудал шинээр дэвшигдэн тавигдаж байна.

XX зууны сүүлчийн улиралд хүн төрөлхтний нэг том нээлт нь амьдрах геополитикийн орон зайгаа цоо шинээр “хязгааргүй тэлсэн” явдал юм. *Cyber space* хэмээх хүний оюуны бүтээл болсон тулааны энэ орон зай хүн төрөлхтний амьдралд онцгой

өөрчлөлт гаргаж, цаашид ч олон онцгой өөрчлөлт, шинэ зүйлсийг буй болгох нь тодорхой байна. Хүн төрөлхтөн дижитал оюун ухаанд сууриласан аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгалын босгон дээр нэгэнт ирэв.

Олон туйлт дэлхийн шинэ бодлогын үзэл санаа анхлан 1997 оны 4 дүгээр 23-нд Москвад гарын үсэг зурсан «Олон туйлт ертөнц, олон улсын шинэ дэг тогтолцоог цогцлоон байгуулах тухай Орос-Хятадын Хамтарсан Тунхаглалд»¹ тусгалаа олсон юм. Энэхүү үзэл санаа ШХАБ, БРИКС, ЕАЭЗХ-ны орнуудын дээд уулзалтын баримт бичгүүдэд тусгалаа олсоор ирэв.

1996 оны 1 дүгээр сард ОХУ-ын Гадаад хэргийн сайдад шинээр томилогдсон Е.М.Примаков хуучин сайд А.Козыревын атлантзмыг чиглэсэн гадаад бодлогын чиг шугамыг өөрчилж, олон тулгуурт (многовекторная внешняя политика) гадаад бодлогын шинэ үзэл баримтлалыг тунхаглаж, ОХУ Энэтхэг, Хятадтай хамтын ажиллагааг бэхжүүлэхийн чухлыг онцолж, энэ нь өнөөгийн БРИКС-ийн үндэс суурь болсон. Үүнийг л «Примаковын номлол» хэмээн нэрлэж байгаа юм гэж ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.Лавров тэмдэглэсэн байдаг. Е.М.Примаков Годаад хэргийн сайдаар ажиллаж байх цаг дор дээрх Тунхаглалд Б.Ельцин, Зян Зэмин нар гарын үсэг зурсан билээ.

Оросын удирдагч В.Путин 2007 онд Мюнхений аюулгүй байдлын зөвлөлгөөн болон 2014 онд Валдай олон улсын мэтгэлцээний клубт хэлсэн үгэндээ олон туйлт дэлхий

ертөнц бүрэлдэж буй тухай маш тодорхой байр сууриа илэрхийлж байсан юм.

ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.Лавров 2016 оны 4 дүгээр сард Монголд айлчилж, хоёр орны хооронд “Стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр”-т гарын үсэг зурах үеэр ГХЯ-нд хийсэн уулзалтан дээр тэмдэглэхдээ: «Дэлхий ертөнц өнөөдөр түүхэн шинэ эрин үед шилжин орох шатандаа ирээд байна. Энэ бол бидний хийж буй ул суурьтай дүгнэлт юм. Өнөөдөр олон улсын харилцааны олон төвт бүтэц бий болж байна. Сүүлийн жилүүдэд өрнөж буй үйл явдлууд нь нэг туйлт ертөнц бий болгох оролдлого хийгээд дэлхий дахинд ганцаар давамгайлах хүсэл эрмэлзэл нь төөрөгдөлд хүргэдэг болохыг харуулж байна. Өнөөгийн нөхцөл байдалд дэлхийн аль ч улс орон, хамгийн хүчирхэг нь байлаа ч тэр, хэсэг бүлэг орнууд байгаад ч тэр орчин цагийн тулгамдсан асуудлуудыг дангаараа үр дүнтэйгээр шийдвэрлэх гэж оролдоод ч нэмэргүй нь илт болжээ. Ийм нөхцөл байдал үүссэн үед бүгдэд тулгарч буй асар том сорилт хийгээд аюул заналд оновчтой хариу барих үүднээс дэлхийн тавцан дахь үндсэн гол тоглогчдын жинхэнэ бодитой түншлэлд тулгуурлан үндэсний эрх ашиг болон хамтын дипломат үйл ажиллагааны хоорондох ухаалаг тэнцвэрийг эрж хайх нь чухал боллоо»² гэжээ.

Бид олон улсын харилцааны олон туйлт дэлхийн шинэ дэг тогтолцоонд дасан зохицож, урагш алхах шаардлагатай нь мэдээж.

ОХУ, БНХАУ-аар

¹ Российско-Китайская совместная декларация о многополярном мире и формировании нового международного порядка. Москва, 23 апреля 1997 года (текст документа с изменениями и дополнениями по состоянию на ноябрь 2007 года)


² Выступление и ответы на вопросы Министра иностранных дел России С.В.Лаврова на встрече в МИД Монголии, Улан-Батор, 14 апреля 2016 года

тэргүүлсэн олон улсын харилцааны олон туйлт төв төлөвших хандлага идэвхиж байгаа нь хүйтэн дайн дууссанаас хойш тогтсоор ирсэн олон улсын дэг тогтолцоо, аюулгүй байдлын системд ноцтой нөлөө үзүүлж эхлэв хэмээн Өрнөдийн судлаачид үзсээр байгаа юм. Энэ нь хүчний томоохон шилжилт хөдөлгөөн явагдаж байна гэж үзэхэд хүргэж байгаа юм. Их гүрнүүдийн геополитикийн далд сөргөлдөөн ил болж, **тиймээс хүйтэн дайн дууссаны дараах үе төгсгөл болж, шинэ хүйтэн дайны үе эхэллээ хэмээн тэмдэглэх нь ч буй.** Орос-Америкийн харилцаа хүйтэн дайны үеэс ч доод түвшинд хүрсэн хэмээн тодорхойлж байна. Хэдийгээр их гүрнүүдийн цэргийн зардал нэмэгдэж байгаа ч энэ нь дайн гарах гол үндэслэл биш, харин аюулгүй байдлаа баталгаажуулж буй хэрэг, их гүрний байр суурь, сүр хүчээ харуулж буй хэрэг, хүчний дахин тэнцвэржүүлэлт, хүчний томоохон шилжилт явагдаж мөн орлогын чухал эх сурвалж болж байна. Их гүрнүүд гадаад бодлогоо тодорхойлохдоо: *economics of power* буюу хүчний эдийн засаг, *power of economics* буюу эдийн засгийн хүч гэсэн 2 зарчмийг баримталж байна.

ОХУ-ын сэргэлт, БНХАУ-ын үсрэнгүй хөгжил, дурдсан хоёр их гүрний бүх талыг хамарсан стратегийн хамтын ажиллагаа, түншлэлийн харилцаа нь олон улсын харилцааны шинэ дэг тогтолцоо тогтон хөгжихөд гол нөлөө үзүүлж байна. 2016 оны 10 дугаар сард Энэтхэгийн Гоа мужид зохиогдсон БРИКС-ийн дээд уулзалтаас гаргасан Гоагийн Тунхаглалд: “...зөвхөн олон улсын эрхзүйг дээдэлж, НҮБ-ын гол үүрэгт суурилсан олон

туйлт олон улсын дэг журмыг цогцлоон байгуулах” тухай шинэ нэр томёогоор заасан байна. Гэхдээ олон туйлт дэлхийн шинэ дэг тогтолцоо төлөвших үйл явц гэдэг нь АНУ, ЕХ-ноос ангид биш, харин тэдгээрийн хамт Орос, Хятад, НҮБ-ыг оролцуулан авч үзэх нь зүй ёсны хэрэг юм.

Эдүгээ **Монгол Улс олон туйлт дэлхийн шинэ дэг тогтолцоо төлөвших үйл явцын татах хүчний яг төвд нь оршиж байна.** Орос-Хятадын харилцаа иж бүрэн стратегийн түншлэлийн багтай түвшинд хүрсэн нь Монгол Улсын гадаад хамгийн ойр орчин сайн байна гэж болох юм. БНХАУ Хятад, Оросын харилцаа хэзээ ч холбоотны харилцаанд эргэж очихгүй гэдгийг тэмдэглэсэн.



ОХУ, БНХАУ-ын оройлолтой олон туйлт дэлхийн шинэ дэг тогтолцоо төлөвших үйл явцад ШХАБ, БРИКС (судлаачид Бразил, ӨАБНУ-ын эдийн засгийн хүндрэлтэй байдлаас БРИКС-ийн үүрэг бүдгэрч байна гэж үзэж байсан. 2017 оны 9 дүгээр сард Хятадын Сьямань хотод зохиогдсон дээд уулзалтын дараа байр сууриа дахин сэргээсэн гэж хэлж болно), ЕАЭЗХ, АДБХОБ, “Нэг бүс, нэг зам” мега төсөл чухал үүрэг гүйцэтгэж байна гэж үзэж байгаа юм.

Олон туйлт дэлхийн шинэ дэг тогтолцоо төлөвших үйл явцад

Монгол Улсын хоёр хөрштэй тэнцвэртэй харьцах бодлого, гурвалсан хөршийн бодлого, «гуравдагч хөрш»-ийн бодлогын хооронд хүчний тэнцвэр, эрх ашгийн тэнцвэрийг зохист түвшинд барих явдал чухал боллоо. *Украины хямралын үндсэн шалтгаан нь Орос, ЕХ-ны хооронд стратегийн тэнцвэр, ашиг сонирхолын тэнцвэрийг барьж чадаагүйд оршино. Тийнхүү бие биенийхээ эрх ашигт хэрхэн нөлөөлөхгүй байх тухай асуудал чухал болов.*

Монгол Улсын хоёр хөрш, «гуравдагч хөрш»-үүдийн хооронд геополитикийн сөргөлдөөн гүнзгийрч, эдийн засгийн хориг арга хэмжээ өргөжиж, газар нутгийн маргаан үргэлжилсээр байна. Тийнхүү Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлогоо хэрэгжүүлж буй гадаад орчин 1990-ээд оноос үндсээрээ өөрчлөгдсөн гэдгийг тэмдэглэж байгаа юм. Энэхүү өөрчлөлтийн үйл явц Монгол Улсын гурван хөршийн хамтын ажиллагаанд эерэг сайн, харин «гуравдагч хөрш»-ийн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлд сөрөг нөлөө үзүүлж болох талтай. Хувьсан өөрчлөгдсөөр буй сорилтод шийдвэртэй, тогтвортой хариу барих арга барилаа олох, өөрчлөлтөд бэлэн байх, дасан зохицох төдийгүй, өөрчлөлтийг хийх чадавхитай байх явдал шийдвэрлэгч нөлөөтэй.

ОХУ эдийн засгийн хориг арга хэмжээний хүнд үеийг даван туулж, газрын тосны үнийн өсөлтийн нөлөөгөөр тус улсын эдийн засаг сэргэж байна. Хятадын эдийн засаг тогтворжилтоос эрчимтэй үер үүгээ шилжиж, хоёр хөршийн удирдагчдын 2 дахь бүрэн эрхийн хугацаа хүчин төгөлдөр болж байна.



Т.Заяа

Олон улсын эрх зүй судлаач

◀ Түүрүүч нь 2017 оны №6-д -т гарсан

ӨӨРТӨӨ ЗАСАН ТОГТНОХ ЭРХ ҮҮ, СЕПАРАТИЗМ ҮҮ?

Сепаратизм буюу салан тусгаарлах үзлийг орчин үеийн улс төрийн харилцаанд зөвхөн улс төрийн эрхээс гадна харилцаанд оролцогч аль нэг субъектын тодорхой нэг асуудлаар (нийгэм, соёл, шашин, хэл, угсаа үндэс г.м) бие даасан шийдвэр гаргах эрх гэж ойлгож болох юм. Энэхүү таамаглал нь дээр дурьдсанчлан салан тусгаарлах үзлийг нэг мөр тайлбарласан олон улсын хэм хэмжээ байхгүй байгаагаар холбоотой юм. НҮБ-ын Дүрэм болон түүний хүрээнд батлагдсан бусад баримт бичигт сепаратизмыг “улс үндэстний өөртөө засан тогтнох эрх”, “нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал” гэсэн зарчимтай холбон тайлбарладаг. Гэвч эдгээр баримт бичиг нь орчин үед үүсээд байгаа сепаратист хөдөлгөөнүүд, тэдгээрийн хөгжил, идэвхжлийг нэмэгдүүлэхэд түлхэц болж буй бас нэг шалтгаан болоод байгаа. Энэ нь нэг талаас өөртөө засан тогтнох эрхтэй үндэстэн угсаатан, нөгөө талаас нутаг дэвсгэрийнхээ бүрэн бүтэн байдлыг хадгалах сонирхолтой улсын эрх зэрэг нь хоорондоо зөрчилдөж байгаа гэсэн ойлголтыг төрүүлэхээр байгаа. Иймд сепаратизмын талаар нэгдсэн нэг ойлголт байхгүй бөгөөд энэ асуудлыг

олон улсын харилцааны онолын хувьд дээрх хоёр зарчмын хүрээнд авч үзвэл:

Сепаратизмыг улс төр, нийгэм, соёл, уламжлал, зан заншил, угсаатан үндэстний гэх зэргээр ангилдаг. Тус бүрээр нь авч үзвэл:

1. Улс гүрнүүд өөрийн газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хадгалах (империалист) үүднээс сепаратист хөдөлгөөнийг хориглосон, хязгаарласан арга хэмжээ авч үүнийгээ бүс нутгийн (ШХАБ-аас баталсан Сепаратизм, экстремизм, терроризмтэй тэмцэх тухай 2001 оны конвенц), дотоодын эрх зүйгээрээ (ОХУ, БНХАУ, Испани зэрэг улсууд) шийдвэрлэж, салан тусгаарлах хөдөлгөөнийг өрнүүлж буй цөөнхийг “хүчээр” барьж байгаа нь реалист онол дахь хүчний бодлого (power politics) гэсэн үзэл баримтлалд нийцэж буй юм.

2. Салан тусгаарлах гэж буй нутаг дэвсгэрийн тодорхой нэг асуудлаар (соёл, хэл, шашин шүтлэг, угсаатан үндэстний асуудлаар) бие даасан шийдвэр гаргах эрхийг олгож буй нь (автономизм - ОХУ, БНХАУ,

Канад г.м улсууд автономт нэгж, өргөн хүрээний автономит нэгж, тусгай нэгжийн статусыг олгох гэх мэт) сепаратист хөдөлгөөнийг “улс үндэстний өөртөө засан тогтнох эрх”-ийн зарчмыг баримтлан хагас улсын статустайгаар хүлээн зөвшөөрч шийдвэрлэж байгаа явдал юм. Үүний тод жишээ Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын 1975 оны Хельсинкийн Төгсгөлийн актад дурьдагдсан байдаг (Бодлогын мэдээ. 2017.12 №6). Энэхүү хэм хэмжээ нь ЕХ-ны гишүүн улсуудын хувьд хувь хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, эрх зүйт төр, ардчиллыг хүндэтгэн дээдлэх зэрэг либерал онолын тулгуур ойлголтуудад (Ж.Локк, Ж.Бентон, И.Кант) хамаарч байна. Европын улсууд хамтран ЕХ-ны хүрээнд сепаратизмын асуудлыг эв зүйгээр зохицуулж байгаа нь либерал институционал онол (Р.Козейн, М.Дойл г.м)-оор мөн тайлбарлагдаж болох юм.

3. Автономит нэгжүүд нь (ОХУ-ын автономт нэгжүүд, Тайвань, Хонг Конг, Канадын Квебек, Испанийн Каталон) соёл, боловсрол, байгаль орчин, шашин шүтлэг, хэл, зан заншлын асуудлаар бие даасан

эрх зүйн субъект болж байгаа нь олон улсын харилцааны (ОУХ) конструктивизмын онолд тулгуурлана. Тухайлбал, конструктивизмын онолыг баримтлагчид (А.Вендт, П.Катценштайн г.м) ОУХ нь нийгмийн байгууллагаас бүрэлдэн бий болдог хэмээн үздэг. Энэ утгаараа нийгмийн санаа, итгэл үнэмшил, үзэл бодлыг чухалчилдаг.

4. Сепаратист үзэл нь либерал реалист онол хэмээн зарим тохиолдолд нэрлэгддэг “The English School” буюу Англи дэг сургуулийн чухалчилдаг “institution- байгуулал”, “values- үнэт зүйлс”, “mutually perceptible interest –харилцан хүлээн зөвшөөрөгдсөн ашиг сонирхол”-той мөн нийцэж байна (Х.Балл, Б.Бузан). Х.Балл үзэхдээ “үндэстэн-улсуудын хооронд ёс суртахууны дүрэм үйлчлэх ба үүнд өөртөө засан тогтнох эрх, дотоод хэрэгт үл оролцох, бүрэн эрхт улсууд адил тэгш эрх эдлэх асуудал хамаарна ” гэсэн онолын үзэл баримтлалтай нийцэж буй юм. Энэ тухай тэрээр өөрийн The Anarchical Society: A Study of Order in world politics (1977) хэмээх номондоо авч үзсэн байдаг. Энэ утгаараа сепаратизмын асуудлыг ЕХ-ны хүрээнд шийдвэрлэсэн байдалтай нийцэж байна.

5. Сепаратист үзлийн биеллээ олж буй нэг хэлбэр нь сепаратист хөдөлгөөнүүд юм. Эдгээр хөдөлгөөн нь эдийн засгийн, нийгмийн баялаг, хөдөлмөрийн тэгш бус хувиарлалттай тэмцэх хэлбэрээр гарч ирдэг бөгөөд үүнийг марксист онолын үүднээс “ангийн тэмцэл”, “хөдөлмөрийн мөлжлөг” (V.Lenin) хэмээн тайлбарлаж болох юм. Тухайлбал, Испаний

аж үйлдвэржсэн Каталон мужид өрнөсөн сепаратист хөдөлгөөн идэвхжих болсон гол шалтгаан нь эдийн засгийн хөгжил юм. Хөгжлөөрөө доогуурт тооцогддог Андалус, Галис, Кастиль зэрэг мужийг бусад нь цаашид “тэжээхээ больёо” хэмээн эсэргүүцдэг. Мөн Валлерстайн, Галтунгийн (Wallerstein, J.Galtung) дэлхийн капиталист эдийн засгийг “перифери, семи-перифери, цөм”-д хуваасан нь сепаратизмыг бие даасан автономт муж, арай илүү автономт эрхтэй нэгж, бие даасан улсын хэлбэрээр тухай бүрдээ тусгаар тогтнож буйтай адилтгаж ойлгож болох юм.

Монгол Улсын хувьд: олон улсын харилцаа, аюулгүй байдал, хамтын ажиллагааны өргөн хүрээний асуудлыг хэлэлцэн бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй оролцдог **Европын Аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын (ЕАБХАБ)**-ын 57 дахь оролцогч улс болсон¹. Энэ утгаараа тус байгууллагын үндсэн баримт бичиг болох Хельсинкийн Төгсгөлийн Акт дурдсан “үндэстэн хоорондын зөрчил мөргөлдөөнийг аль ч улс, хэсэг бүлэг улс хүч хэрэглэхгүйгээр, аль нэгнийхээ дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохгүйгээр шийдвэрлэнэ” гэсэн зохицуулалтыг даган биелүүлнэ.

ШХАБ: Монгол Улс нь ШХАБ-д 2004 оноос эхлэн ажиглагчийн статустай болсон.

ШХАБ-ыг үүсгэн байгуулах тухай 2001 оны “ШХАБ-ын Тунхаглал”, мөн 2001 оны “Шанхайн конвенц” зэрэг үндсэн баримт бичгүүдэд тухайн байгууллагын үндсэн зорилгод

гурван “изм” буюу терроризм, сепаратизм, экстремизмтэй тэмцэх” тухай асуудал хамаардаг. Ингэхдээ дээрх гэмт хэргүүдийн сэдэлтээс (мотив) үл хамааран гишүүн улсууд хатуу тэмцэх үүргийг хүлээж Бишкект төвтэй бүс нутгийн хэмжээний бүтцийг байгуулах тухай тохиролцсон байдаг.²

Монгол Улс нь терроризмтэй тэмцэх асуудлаар НҮБ-ын хүрээний олон улсын олон гэрээ, конвенцид нэгдэн орсон байдаг. Терроризмыг санхүүжүүлэгч гол эх үүсвэр нь сепаратизм, экстремизм байдаг ба үүнийг дагаад олон улсын ба олон улсын шинжтэй гэмт хэргүүд, тухайлбал хар тамхи, хүний наймаа, мөнгө угаах зэрэг гэмт хэргүүд үүнд хамаарна. Дээрх бүхэнтэй тэмцэх бүс нутгийн хэмжээний механизмыг ШХАБ бий болгож буй юм. Үүнийг дагаад эрх зүйн хувьд харилцан туслалцах, шүүх, арбитрын шийдвэрийг харилцан хүлээн зөвшөөрөх, шүүх, прокурор, аудит зэрэг мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагаа тухайн байгууллагын гишүүн улсуудын хооронд өргөнөөр хөгжих³, мөн олон улсын эрх зүйн нэг салбар болох бүс нутаг дахь олон улсын эрүүгийн эрх зүй хөгжих нэг үндэс болж болох юм.

2 Art. 1. The Shanghai Convention on Combating Terrorism, Separatism and Extremism. 2001.

3 Art.5-8. Declaration on the Establishment of the Shanghai Cooperation Organization. 2001.

1 <https://mn.embafrance.org>

ГАДААД ХУДАЛДАА

2018 ОНЫ 4-Р САР



Гадаад худалдааны нийт бараа эргэлт 3.7 тэрбум америк доллар, үүнээс экспорт 2.1 тэрбум америк доллар, импорт 1.6 тэрбум америк долларт хүрлээ.

Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 690.0 (22.9%) сая америк доллар, үүнээс экспорт 225.8(11.9%) сая америк доллараар, импорт 464.2 (41.5%) сая америк доллараар тус тус өссөн байна.

Экспорт 2018 оны эхний 4 сард өмнөх оны мөн үеэс 225.8 сая америк доллараар өсөхөд боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алтны экспорт 68.8 сая америк доллар, үнэт, хагас үнэт чулуу, металл гоёлын зүйлсийн экспорт 68.7 сая америк доллараар өссөн нь голлон нөлөөлсөн байна.



Импорт өмнөх оны мөн үеэс 464.2 сая америк доллараар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний импорт 90.3 сая америк доллар, үүнээс дизелийн түлш 56.9 сая америк доллар, машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг, эд анги 120.6 сая америк доллараар, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги 78.6 сая америк доллараар, үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн бүтээгдэхүүний импорт 56.8 сая америк доллараар өссөн нь голлон нөлөөлжээ.

НОМЫН ЕРТӨНЦӨӨР

Бага орны дотоод зовлон /Монголчуудын жишгээр/



Тойтогийн Төмөрхүлэг хэмээх эрхмийг манай уншигчид андахгүй. Тэрбээр саяхан “Бага орны дотоод зовлон” нэрээр нэгэн ном туурвиж өргөн барьсан нь олны сонирхлыг эрхгүй татаж, багагүй шуугиан ч тариад амжив бололтой. Зохиогчийн өөрийнх нь өгүүлснээр “...монголчуудынхаа агуу өгөөмөр сэтгэл, чин үнэнч зан, хийморь цогтой үйлс, үүний сацуу хүмүүсийн шалдар булдар байдал, эрээн бараан явдал, базаахгүй зуршил, болчимгүй үйлдэл, хөшүүн хойрго сэтгэхүй тэргүүтнийг түүж эвлүүлэн...” бичихдээ “... өөрсдийгөө таниж мэдэх гэсэн элэг нэгт түмэндээ үүгээрээ өчүүхэн ч атугай тус хүргэх...” зорилго өвөрлөжээ. Номынхоо магнайг мялааж “Хүн гэмээ мэддэггүй, тэмээ гэдгэрээ мэддэггүй” хэмээх монгол ардын зүйр үг болон “Би түмэн олондоо хайртайдаа тэднийхээ болохгүй бүтэхгүйг заавал хэлж засахыг мэрийдэг” хэмээх М.Задорновыг эшлэсэн байна.

Амьдрал бол өөрийгөө танин мэдэх явдал юм гэж нэгэн номч мэргэн нэгэнтаа айлдсан байдаг. Т.Төмөрхүлэг гуай бидний монголчуудын амьдралыг танин мэджээ. Х.Б.

📍 Монгол улс, Улаанбаатар хот, СБД,
МУИС-ОУХНУС V байр 308 тоот

✉ thinktanks99@gmail.com

☎ 976 99070579

☎ 976-11354610

